



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/71

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2024 оны 1 дүгээр хурал, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарлан улсын Онцгой комиссоос ажлын хэсэг аймагт ажиллаж байгаа, аймгийн Шуурхай штабын үйл ажиллагааг 24 цагаар тогтмол ажиллуулах болсон, их хэмжээний цас орсны улмаас хаагдсан зам, давааны замыг нээж хэвийн байдал оруулах, зарим суманд шар усны үерийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан авах арга хэмжээг санхүүжүүлэх зэрэг зардлын жагсаалт, санхүүжих мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан ажил, арга хэмжээний зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)- д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 21-ний өдрийн А/7/
захирамжын хавсралт
/төгрөгөөр/

ДД	Зардлын зүйл	Мөнгөн дүн
1	Өвөлжилтийн байдал эрс хүндэрсэн Шинэ-Идэр, Жаргалант, Галт, Төмөрбулаг сумдын чиглэлд цас их орсон тул хаагдсан зам даваа нээхэд аймгаас явсан ковшны шатахууны зардал	1,500,000
2	Цас их орсноос хаагдсан зам давааны замыг нээж өвс тэжээл тээвэрлэх, иргэд зорчих боломж бүрдүүлэхэд Галт, Шинэ-Идэр сумдаас ажилласан тээврийн хэрэгслийн шатахууны зардал. /2 суманд тус бүр 1.5 сая/	3,000,000
3	Өвөлжилтийн байдал эрс хүндэрсэн Цэцэрлэг, Цагаан-Уул, Могойн голын уурхайн чиглэлд цас их орсон тул хаагдсан зам даваа нээх, Дулааны станцын нүүрс татах зам гаргах ажилд ажилласан автомашины шатахууны зардал	1,040,000
4	Өвөлжилтийн байдал эрс хүндэрсэн Цэцэрлэг, Цагаан-Уул, Могойн уурхайн чиглэлд хаагдсан зам даваа нээх ажилд дайчлан ажиллуулсан автомашины эвдрэлийг засах засварын зардал	550,000
5	Цэцэрлэг сумын өвөлжилтийн байдал эрс хүндэрч зудын Их эрсдэлтэй түвшинд хүрсэн бөгөөд сумаас малчдадаа хүрч ажиллахад нь шатахууны дэмжлэг үзүүлэх	2,000,000
6	Улсын онцгой комиссын ажлын хэсэг өвөлжилт хүндэрсэн сумдад өвс тэжээл хүргэхэд бэлтгэл хангах /ачааны хучлага татлага, аннос/	500,000
7	Аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб 24 цагаар ажиллаж байгаа тул үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах зардал	2,005,500
8	Улсын онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаварын дагуу цас зуд ихтэй сумдаар явж хүндэрсэн нөхцөл байдлын талаар зураг авах, бичлэг хийж богино хэмжээний баримтат кино болгон явуулах ажлын шатахууны зардал	560,000
9	Рэнчинлхүмбэ суманд үүссэн шар усны үерээс хамгаалах, далан шуудуу барих, шатахууны өр барагдуулах зардалд дэмжлэг үзүүлэх	4,000,000
10	Тариалан суманд үүссэн шар усны үерээс хамгаалах, далан шуудуу барих, шатахууны өр барагдуулах зардалд дэмжлэг үзүүлэх	1,000,000
11	Тариалан сумын холбоо шатаж харилцаа холбоо тасалдсан тул сэргээн засварлах, тоног төхөөрөмж авах зардалд дэмжлэг үзүүлэх	2,000,000
Дүн		18,155,500